



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/212

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.14, 15.3.4 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын 2019 оны “Хүний нөөцийн бодлого батлах тухай” А/70, “Цэргийн мэргэжлийн боловсрол, шаталсан сургалтын тогтолцоо батлах тухай” А/159 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалахын удирдлагын академид элсэгчийг сонгон шалгаруулах, суралцуулах журам”-ыг хавсралтаар баталж, мөрдсүгэй.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Журам батлах тухай” А/113 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Н.Пүрэвдорж)-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1322100208

Батлан хамгаалахын сайдын 2024 оны  
06 дугаар сарын 25-ны өдрийн  
А/212 дугаар тушаалын хавсралт

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН БАТЛАН  
ХАМГААЛАХЫН УДИРДЛАГЫН АКАДЕМИД ЭЛСЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ, СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Батлан хамгаалах салбар, Төрийн цэргийн байгууллагуудын захиалга болон гадаад харилцаа, цэргийн хамтын ажиллагааны хүрээнд Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалахын удирдлагын академид элсэн суралцах офицер (цаашид “элсэгч” гэх)-ыг сонгон шалгаруулах, суралцуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Энэхүү журмын зорилго нь Батлан хамгаалах салбар, Төрийн цэргийн байгууллагын удирдах албан тушаалд ажиллах, зөв хандлага, төлөвшил, ёс суртахуунтай элсэгчийг сонгон шалгаруулж, Батлан хамгаалахын удирдлагын академид суралцуулахад оршино.

1.3. Батлан хамгаалахын удирдлагын академид элсэгчид тавигдах шаардлагыг тодорхойлох, элсэгчийг сонгон шалгаруулалт, элсэлтийн шалгалтыг зохион байгуулах, суралцах эрх олгох, суралцуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.4. Төрийн албаны тухай, Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Дээд боловсролын тухай хуулиуд, Батлан хамгаалахын сайдын 2019 оны “Хүний нөөцийн бодлого батлах тухай” А/70, “Цэргийн мэргэжлийн боловсрол, шаталсан сургалтын тогтолцоо батлах тухай” А/159 дүгээр тушаалууд болон холбогдох бусад хууль тогтоомж нь энэхүү журмыг боловсруулах эрх зүйн үндэслэл болно.

1.5. Элсэгч нь дотоодын болон гадаадын цэргийн их сургууль төгссөн, цэргийн ухааны бакалавраас доошгүй зэрэгтэй, албан тушаалын болон мэргэшүүлэх сургалтад хамрагдаж төгссөн, батальон (дивизион)-ы захирагчийн орлогч, тусгай салбарын захирагч, түүнтэй адилтгах буюу түүнээс дээш албан тушаалд 2-оос доошгүй жил ажиллаж байгаа, 37 хүртэлх насны, ахмад түүнээс дээш цолтой, 10-аас доошгүй жил тухайн салбартаа ажилласан офицер байна гэсэн ерөнхий шаардлага тавигдана.

1.6. Элсэгчид дараах нийтлэг шаардлага тавигдана:

1.6.1. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1-д заасан нийтлэг үүрэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн болон Цэргийн алба хаагчийн ёс зүйн шаардлагыг хангасан байх;

1.6.2. батлан хамгаалах болон төрийн цэргийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж байгаа, анги, байгууллага, хамт олондоо нэр хүндтэй, зөв хандлагатай, зан харилцаа, ёс суртахууны хувьд төлөвшсөн байх;

1.6.3. төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин нь сүүлийн 2 жилд “Хэвийн” түүнээс дээш үнэлэгдсэн, офицерын түвшин тогтоох үзлэг, цогцолбор ба командлалын шалгалт, сургуулийн

жилийн төгсгөлийн шалгалтаар “Сайн” түүнээс дээш дүнтэй шалгагдсан байх;  
1.6.4.гадаад хэлний анхан болон түүнээс дээш шатны мэдлэгтэй, компьютерын хэрэглээний үндсэн программуудыг зохих түвшинд эзэмшсэн байх.

### Хоёр. Элсэлтийн сонгон шалгаруулалт

2.1. Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь Батлан хамгаалахын удирдлагын академид суралцуулах элсэгчийн тоо, цэргийн мэргэжлийн чиглэлийг жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор Батлан хамгаалах яамны харьяа байгууллагууд болон төрийн цэргийн байгууллагуудад хүргүүлнэ.

2.2. Сонгон шалгаруулалтыг (цаашид “шалгаруулалт” гэх) Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилогдсон, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргаар ахлуулсан “Элсэлтийн шалгалтын комисс” зохион байгуулна.

2.3. Шалгаруулалтыг хичээлийн жил эхлэхээс 2 сарын өмнө явуулсан байна.

2.4. Шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгуулна:

2.4.1. яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь БХЯ-ны вэбсайт (<http://www.mod.gov.mn>), ЗХЖШ-ын вэбсайт (<http://www.gsmaf.gov.mn>) болон “Соёмбо” сониноор шалгаруулалт эхлэхээс 3 сарын өмнө нээлттэй зарлана;

2.4.2. элсэгч нь шалгаруулалтад оролцох хүсэлтээ Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллагын захирагч /дарга/ -д бичгээр гаргана;

2.4.3. нэгтгэл, анги, байгууллага нь энэхүү журмын 1.5, 1.6-д заасан шаардлагыг хангасан элсэгчийн материалыг мөн журмын 2.4.4, 2.4.5-д заасны дагуу бүрдүүлж, тухайн жилийн 05 дугаар сарын 25-ны дотор харьяалах байгууллагын мэргэжлийн хэлтэс, газар, командлалд хүргүүлнэ.

2.4.4. Элсэгч нь дараах материалыг бүрдүүлнэ:

2.4.4.1. шалгаруулалтад оролцох хүсэлт бүхий өргөдөл;

2.4.4.2. төрийн албан хаагчийн анкет;

2.4.4.3. иргэний үнэмлэх, офицерын үнэмлэхийн хуулбар (цол, албан тушаалд томилогдсон хуудасны хамт);

2.4.4.4. цэргийн мэргэжлийн болон бакалаврын диплом, албан тушаалын болон мэргэшүүлэх сургалтын гэрчилгээний хуулбар, хавсралтын хамт;

2.4.4.5. сурлагын дэвтрийн хуулбар (сүүлийн 2 жилд хамрагдсан түвшин тогтоох, цогцолбор, командлалын шалгалтын дүн);

2.4.4.6. цагдаагийн байгууллагын тодорхойлолт.

2.4.5. нэгтгэл, анги, байгууллага нь элсэгчтэй холбоотой дараах материалыг бүрдүүлнэ:

2.4.5.1. нэгтгэл, анги, байгууллагын захирагч /дарга/-ийн санал;

2.4.5.2. захирагч /дарга/-ийн зөвлөлийн хуралдааны шийдвэр;

2.4.5.3. ажил байдлын тодорхойлолт;

2.4.5.4. элсэгчийн төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээний хуулбар, цогцолбор ба командлалын шалгалтын дүнгийн хуулбар (сүүлийн 2 жилээр).

2.4.6. мэргэжлийн хэлтэс, газар, командлал нь нэгтгэл, анги, байгууллагаас ирүүлсэн материалыг хянан хэлэлцээд 06 дугаар сарын 01-ний дотор Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлнэ;

2.4.7. төрийн цэргийн болон яамны харьяа байгууллагууд санал, холбогдох материалаа 06 дугаар сарын 10-ны дотор Батлан хамгаалах яаманд

хүргүүлнэ;

2.4.8. яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь энэхүү журмын 2.4.7-д заасан байгууллагаас ирүүлсэн санал, журмын 2.4.4, 2.4.5-д заасан материалыг судлан нэгтгэж, энэхүү журмын 1.5, 1.6-д заасан шаардлагыг хангасан элсэгчийн материалыг Элсэлтийн шалгалтын комисст (цаашид “комисс” гэх) хүлээлгэн өгнө;

2.4.9. комисс нь шалгаруулалтад ирүүлсэн элсэгчийн материалыг хянан хэлэлцээд элсэгчдийн нэрийн жагсаалтыг гаргаж, яамны Төрийн нарийн бичгийн даргад танилцуулна;

2.4.10. комисс нь элсэгчдийг Цэргийн төв эмнэлэгт эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах арга хэмжээг зохион байгуулна;

2.4.11. цэргийн эмнэлгийн комисс нь Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ын дагуу элсэгчийн биеийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлон дүгнэлт гаргаж, холбогдох материалыг комисст хүргүүлнэ.

2.4.12. комисс энэхүү журмын 1.5, 1.6-д заасан шаардлагыг хангасан, биеийн эрүүл мэндээр тэнцсэн элсэгчийг шалгаруулалтад хамруулна.

2.5. Элсэгчийг дараах тохиолдолд шалгаруулалтад оролцуулахгүй:

2.5.1. баримт бичгийн бүрдэл дутуу;

2.5.2. эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдаагүй;

2.5.3. шалгаруулалтын явцад сахилгын зөрчил гаргасан болон гэмт хэрэг, зөрчилд холбогдсон.

2.6. Элсэлтийн шалгалт:

2.6.1. элсэлтийн шалгалт нь Биеийн тамирын бэлтгэлийн болон Онолын цогцолбор шалгалтуудаас бүрдэнэ.

2.6.2. биеийн тамирын бэлтгэлийн шалгалтыг ЗХЖШ-ын даргын тушаалаар батлагдан мөрдөж буй “Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт”-ын дагуу явуулна. Биеийн тамирын бэлтгэлийн шалгалтад тэнцсэн элсэгч нь Онолын цогцолбор шалгалтад орох эрх үүснэ.

2.7. Онолын цогцолбор шалгалтыг дараах төрлөөр зохион байгуулна:

2.7.1. ерөнхий тактикийн цогцолбор;

2.7.2. бичгийн;

2.7.3. хууль, эрх зүйн;

2.7.4. гадаад хэлний.

2.8. Ерөнхий тактикийн цогцолбор шалгалт нь элсэлтийн үндсэн шалгалт байх бөгөөд онолын болон дадлагын хэлбэрээр явуулна. Онолын шалгалтыг Байлдааны дүрэм (БД-2/100)-ийн түвшинд төрөл, тусгай мэргэжлийн салбаруудыг хэрэглэх, бүх төрлийн хангалт, удирдлагыг зохион байгуулах асуудлын хүрээнд тестээр, дадлагын шалгалтыг тактикийн шуурхай дадлагаар тус тус боловсруулна.

2.9. Бичгийн шалгалтыг элсэгчийн найруулга зүйн ур чадварын түвшинг тогтоох зорилгоор “Эсээ” бичих аргаар явуулна. Элсэгч комиссын бэлтгэсэн сэдвээс сонгож 250-300 үгтэй “Эсээ”-г 45 минутын хугацаанд бичнэ.

2.10. Хууль, эрх зүйн шалгалтыг батлан хамгаалахын болон холбогдох бусад хууль тогтоомж, “Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд”-ийн хүрээнд тестийн аргаар зохион байгуулна.

2.11. Гадаад хэлний шалгалтыг англи болон бусад хэлнээс сонгож, тестийн аргаар зохион байгуулна.

2.12. Онолын цогцолбор шалгалтыг 100 хүртэл оноогоор дүгнэх ба шалгалт тус бүр нь дараах оноотой байна:

2.12.1. ерөнхий тактикийн цогцолбор шалгалт - 50 оноо (тест-20; дадлага-30);

2.12.2. бичгийн шалгалт - 20 оноо;

2.12.3. хууль эрх зүйн шалгалт - 15 оноо;

2.12.4. гадаад хэлний шалгалт - 15 оноо.

2.13. Комисс шалгалтын материалыг урьдчилан бэлтгэж, Комиссын даргаар баталгаажуулж, битүүмжилсэн байна.

2.14. Шалгалтыг тусгай тэмдэг дарсан цаасан дээр гүйцэтгэх ба Тактикийн шуурхай дадлагыг Цэргийн байр зүйн зураг дээр боловсруулна.

2.15. Комисс нь элсэгч бүрд шифр оноож өгнө. Элсэгч нь зааврын дагуу шифрийг шалгалтын цаас, байр зүйн зураг дээр тэмдэглэнэ. Шалгалтын материалд цол, овог нэр бичих болон ямар нэгэн тэмдэг, тэмдэглэгээ тавихыг хориглоно.

2.16. Шалгалтын үед бусдаас дэмжлэг авах, урьдчилан бэлтгэсэн материал ашиглах, бусдад туслах, гар утас болон бусад төрлийн техник, хэрэгсэл ашигласан тохиолдолд элсэлтийн шалгалтаас хасна.

2.17. Шалгалтын төгсгөлд элсэгчдийг онооны дарааллаар байр эзлүүлнэ.

2.18. Элсэгчдийн нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд Ерөнхий тактикийн цогцолбор, Бичгийн, Гадаад хэлний шалгалт гэсэн дарааллаар шалгалтын оноог харгалзан шийдвэрлэнэ.

2.19. Комисс Батлан хамгаалахын сайдын баталсан хяналтын тоонд багтаан шалгалтад тэнцсэн элсэгчдийг Батлан хамгаалахын удирдлагын академид элсүүлэх дүгнэлт гаргана.

2.20. Комиссын дарга шалгалтад оролцсон нийт элсэгчдэд шалгалтын нэгдсэн дүнг нээлттэй зарлаж, яамны Төрийн нарийн бичгийн даргад танилцуулна.

2.21. Гадаад улсын Зэвсэгт хүчний алба хаагчийг элсүүлэн суралцуулах асуудлыг батлан хамгаалахын гадаад харилцаа, цэргийн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэнэ.

2.22. Гадаад улсын элсэгчийн суралцах хугацаанд эдлэх хөнгөлөлт, байр, тэтгэлэг болон бусад хангалтыг хоёр улсын Батлан хамгаалах яамд хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

2.23. Гадаад улсын элсэгчдэд энэхүү журмын 1.5, 1.6-д заасан ерөнхий шаардлага хамаарахгүй бөгөөд бакалаврын зэрэгтэй дүйцэх боловсрол эзэмшсэн, ахмадаас дээш цолтой офицер байна.

#### Гурав. Суралцуулах

3.1. Энэ журмын 2.21-д заасан дүгнэлтийг үндэслэн элсэгчийг Батлан

хамгаалахын удирдлагын академид суралцуулах шийдвэрийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар баталгаажуулна.

3.2. Яамны Төрийн захиргааны удирдлагын газар элсэгчтэй “Суралцах гэрээ”-г байгуулна. Гэрээнд суралцах мэргэжил, хугацаа, нөхцөл, гэрээлэгч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгана.

3.3. Яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь элсэгчийн материалыг холбогдох шийдвэрийн хамт Үндэсний батлан хамгаалахын их сургуульд хүлээлгэн өгнө.

3.4. Орон нутгаас суралцах зарим суралцагчийг суралцах хугацаанд нь орон сууцаар хангах асуудлыг Үндэсний батлан хамгаалахын их сургууль хариуцан шийдвэрлэнэ.

3.5. Суралцагчийн цалин хөлс олгохтой холбогдсон асуудлыг “Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчид цалин хөлс олгох журам”-ын дагуу шийдвэрлэнэ.

3.6. Төрийн цэргийн бусад байгууллагаас суралцаж буй суралцагчдын цалин хөлс, орон байр, бусад хангалтыг тухайн байгууллага хариуцна.

3.7. Суралцагчийг суралцах хугацаанд нь сургалтын материал хэрэгсэл, тоног төхөөрөмж, нөхцөл боломжоор хангах асуудлыг Батлан хамгаалахын удирдлагын академи хариуцна.

3.8. Суралцагч суралцах хугацаандаа төрийн одон, медаль болон салбарын шагналаар шагнагдах, гаргасан амжилтыг үнэлж, урамшуулах, сахилгын зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох хууль тогтоомж, “Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд” болон Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын удирдлагын академийн дотоод журмаар зохицуулна.

3.9. Суралцагчид суралцах хугацаанд нь цэргийн цол олгох асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 136 дугаар зарлигаар батлагдсан “Цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журам”-ын дагуу шийдвэрлэнэ.

3.10. Суралцагч суралцах хугацаандаа хөдөлмөрийн чадвараа 3 сараас дээш түр хугацаагаар алдсан тохиолдолд нөхөж суралцах асуудлыг яамны Төрийн захиргааны удирдлагын газарт өргөдөл гарган шийдвэрлүүлж болно.

3.11. Суралцагчийг Батлан хамгаалахын удирдлагын академиас хасах, түдгэлзүүлэх асуудлыг “Суралцуулах гэрээ”-ний дагуу шийдвэрлэнэ.

3.12. Суралцагчийг суралцах хугацаанд нь Стратегийн дадлагад хамруулах асуудлыг Батлан хамгаалахын удирдлагын академийн төлөвлөлтийн дагуу явуулах бөгөөд гадаад улсад явагдах дадлагад оролцох суралцагчийн тоо, зардлыг тухайн улстай харилцан тохиролцсоны үндсэн дээр зохион байгуулна.

3.13. Үндэсний батлан хамгаалахын их сургууль нь амжилттай төгссөн суралцагчийг Батлан хамгаалах яамны мэдэлд шилжүүлнэ.

3.14. Батлан хамгаалахын удирдлагын академийн сургалтын тусгай хөтөлбөрийн дагуу эчнээ сургалтыг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллагын шийдвэрээр зохион байгуулж болно.

3.15. Энэхүү журмын 1.5, 1.6-д заасан шаардлагыг хангасан, элсэлтийн шалгалтад тэнцсэн элсэгчийг эчнээгээр суралцуулна. Эчнээ сургалтын хугацаа 3 жил байх бөгөөд 1 жилд суралцах суралцагчийн тоог Батлан хамгаалах яамнаас тогтоож өгнө.

3.16. Эчнээ сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн захирлын тушаалаар баталж, мөрдүүлнэ.

#### Дөрөв. Бусад зүйл

##### 4.1. Элсэгчийн эрх, үүрэг:

- 4.1.1. элсэлтийн шалгалтын материал, дүнтэй танилцах;
- 4.1.2. элсэлтийн шалгалт дууссанаас хойш 2 цагийн дотор шалгалттай холбоотой өргөдөл, гомдлоо бичгээр гаргаж шийдвэрлүүлэх;
- 4.1.3. комиссын тогтоосон цагт, заасан газарт бэлэн байх.

##### 4.2. Комиссын эрх, үүрэг:

- 4.2.1. шалгаруулалт, элсэлтийн шалгалтын хугацааг товлох;
- 4.2.2. шалгалтын материалыг бэлтгэж нууцлалыг хангах;
- 4.2.3. холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөн шалгаруулалт, элсэлтийн шалгалтыг шударга, ил тод, нээлттэй явуулах;
- 4.2.4. элсэлтийн шалгалттай холбоотой аливаа маргааныг тухай бүр хянан шийдвэрлэх;
- 4.2.5. журамд тусгагдсан шаардлагыг хангаагүй, холбогдох заалтыг зөрчсөн элсэгчийг шалгаруулалтаас хасах.

4.3. Батлан хамгаалахын удирдлагын академийн элсэлтийг жил бүр зохион байгуулна.

4.4. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнээс бусад төрийн цэргийн байгууллагын бүрэлдэхүүний элсэлтийг 2 жилд нэг удаа зохион байгуулах бөгөөд журмын 3.14-д заасан сургалтад хамаарахгүй.

4.5. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.